

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2020 оны 100 тоот  
тушаалын 7 дугаар хөвсралт

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Д/ д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
<b>ЗОРИЛТ 1. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, СТРАТЕГИЙН ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
1	Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлэлцэж, нэгжийн бодлого, төлөвлөлтийг уялдуулах Төлөвлөлтийн хурлыг зохион байгуулах	-	Зохион байгуулсан хурал /тоо/	0	I	-	Газар, нэгжийн дарга, ахлах шинжээчдийг оролцуулан Монгол Улсын урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр туссан бодлого, арга хэмжээг 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, санал солилцох, уялдааг хангах зорилгоор Төлөвлөлтийн хурлыг зохион байгууллаа. Хурлаар хэлэлцэгдсэн асуудал, гарсан саналын дагуу газар нэгжүүд яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах санал, шалгуур үзүүлэлтээ боловсруулсан.	100%
2	Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд ГБХНХЯ-ны саналыг тусгуулж, батлуулах	-	Батлагдсан төлөвлөгөө /тоо/	0	II	IV	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээг УИХ-д танилцуулсны үндсэн дээр дараагийн таван жилийн үндсэн чиглэлийн төсөл боловсруулах ажил хийгдэнэ. Одоогийн байдлаар 2021-	70%

								2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан нэгтгэгдэж байна. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгах ГБХНХЯ-ны саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу 2025 оны 9 дүгээр сард багтаан нэгтгэн боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхээр төлөвлөж байна.	
3	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	-	Хийгдсэн шинжилгээ /too/	0		-	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны А/06 дугаар тушаалаар байгуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу мандатын, орчны шинжилгээ хийж, стратеги төлөвлөгөөг боловсруулсан. “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/119 дүгээр тушаалаар батлуулсан.	100%	
4	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд ГБХНХЯ-ны саналыг тусгуулж, батлуулах	-	Батлагдсан төлөвлөгөө /too/	0		-	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгах ГБХНХЯ-ны саналыг 2025 оны 1 дүгээр сарын 30-ны 01/323 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.	100%	

								Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээг урьдчилан цахимаар болон 2025 оны 4 дүгээр сарын 18-ны 03/1255 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд мөн хүргүүлж, шаардлагатай мэдээлэл, судалгааг тухай бүр гарган өгсөн. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө Улсын Их хурлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан.	
5	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2025-2030 онд жендерийн талаар баримтлах бодлогыг боловсруулж батлуулах	-	Бодлогын төсөл /тоо/	0	I-II	1	Хүн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2018-2024 оны жендерийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн тайланг боловсруулсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2030 онд жендерийн талаар баримтлах бодлогын төслийг боловсруулсан ба Жендерийн салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан, хэлэлцүүлэхээр бэлтгэв.	75%	
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулах	-	Шинэчлэн боловсруулс ан баримт бичиг /тоо/  Үзэл баримтлал-1  Хуулийн төсөл -1	1	I	IV	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/21 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах техникийн ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан	100%	

								судалгаа, хуулийн төслийн үр нэлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийж гүйцэтгэсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/88 дугаар тушаалаар хуулийн төслийг эцэслэн боловсруулах, хэлэлцүүлэх үүрэг бүхий өргөтгөсөн ажлын хэсгийг хөдөлмөр, нийгмийн түншлэгч талууд болон холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, холбогдох байгууллагуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авч хуулийн төсөлд тусгасан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар салбарын яамд болон холбогдох байгууллагуудад 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/1789, 01/1803 тоот албан бичгээр тус тус хүргүүлж саналыг авч ажиллаж байна. Мөн Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичгийг 2025 оны 01/1879 тоот албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх албан бичгийг, ЗГХЭГ-т 2025 оны 01/1888 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
7	Хөдөлмөрийн тухай нэмэлт, оруулах	-	Боловсруулсан хуулийн төслийн тоо	0	I	IV	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалгааг Хууль тогтоомжийн	100%	

	хуулийн боловсруулах	төсөл						хуульд заасны дагуу хийж гүйцэтгэсэн. Судалгаатай холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн сайдаар батлууллаа. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025 оны 5 дугаар сард яамдаас санал авч нэгтгэлээ. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох бусад баримт бичгийг Засгийн газрын хэрэглэх газарт 2025 оны 6 дугаар сарын 1-нд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар уг хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих нь зүйтэй гэж шийдвэрлэлээ.	
8	УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 103 дугаар захирамжаар байгуулагдсан “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-тэй хамтрах ажиллах	-	Ажлын хэсэгт хүргүүлсэн саналын тоо	0	I	IV	УИХ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 103 дугаар захирамжаар байгуулагдсан “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т Хөдөлмөрийн тухай хуультай мэдээлэл, холбогдох судалгааг хүргүүлэн ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2024 оны 10 дугаар сараас 2025 оны 1 улиралд	100%	

							үнэлгээ хийж, гарсан үнэлгээг тус ажлын хэсэгт хүргүүлсэн. Ажлын хэсгийн хуралд Хөдөлмөрийн тухай хуульд хийсэн үнэлгээний дүнг танилцуулж, ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг тусган үнэлгээний тайланг хүргүүлсэн. Ажлын хэсгээс тус яамнаас хүргүүлсэн тайлан, мэдээ болон бусад байгууллагаас хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын хэсгээс Улсын Их Хурлаас ямар нэгэн шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн. Уг ажлын гишүүдээс гарсан саналын дагуу Хөдөлмөрийн тухай хуультай холбоотой судалгаа, мэдээлэл, тоо баримтыг боловсруулан 2025 оны 5 дугаар сард Төрийн нарийн бичгийн даргын албан бичгээр хүргүүлсэн.	
9	УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 102 дугаар захирамжаар байгуулагдсан "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн хуралд 2025 онд 2 удаа оролцож мэдээлэл хийж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баримталж байгаа байр сууриа илэрхийлж мэдээллээ хүргүүллээ. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос уг ажлын хэсэгт болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлсэн хуулийн төсөлтэй танилцан хуулийн төсөлд оруулах саналаа боловсруулан ажлын хэсэгт хүргүүлж, ажлын хэсгийн хуралд танилцуулсан.	-	Ажлын хэсэгт хүргүүлсэн саналын тоо	0	I	IV	УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 102 дугаар захирамжаар байгуулагдсан "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн хуралд 2025 онд 2 удаа оролцож мэдээлэл хийж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баримталж байгаа байр сууриа илэрхийлж мэдээллээ хүргүүллээ. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос уг ажлын хэсэгт болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлсэн хуулийн төсөлтэй танилцан хуулийн төсөлд оруулах саналаа боловсруулан ажлын хэсэгт хүргүүлж, ажлын хэсгийн хуралд танилцуулсан.	85%

							"Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор Англи Улс, Япон Улс, Сингапур Улс, Вьетнам Улсын үйлдвэрчний эвлэлийн хуулийн судалж, харьцуулсан судалгааг уг ажлын хэсэгт танилцуулсан.	
10	Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бурдүүлэх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, хуулийн төсөлд санал хүргүүлэх	-	Ажлын хэсэгт хүргүүлсэн саналын тоо	0	I	IV	<p>Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бурдүүлэх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ж.Баясгалан ахлан ажиллаж байна. Япон Улсын асрах үйлчилгээний нөхцөл байдалтай танилцах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах зорилгоор УИХ-ын гишүүн Ж.Баясгалангаар ахлуулсан ажлын хэсэг тус улсад туршлага судалж ажилласан. Туршлага судлах багт яамны холбогдох газар, хэлтсийн дарга нар оролцож тус улсын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргаа, сувилгаа, нийгмийн хамгааллын хууль, эрх зүйн чиглэлээр харилцан мэдлэг мэдээллээ солилцож ажилласан.</p> <p>Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бурдүүлэх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгээс 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдөр ГБХНХЯ, ЭМЯ болон бусад холбогдох төрийн болон ТББ-ын байгууллагын төлөөллийг оролцуулсан "Асрах үйлчилгээний эрх зүйн орчин" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Яамны халамжийн хэлтсийн дарга</p>	85%

							Ю.Отгонбилэг, ахлах шинжээч Д.Гэрэлтуяа нар оролцож "Ахмад настны асаргаа, үйлчилгээ өнөөгийн байдал" сэдвээр илтгэл танилцуулсан. Ажлын хэсгээс дараагийн хурлаар асрах үйлчилгээг хэрэгжүүлж байгаа ТББ-уудын танилцуулга, мэдээллийг сонсох, бусад шийдлүүдийг хэлэлцэхээр тогтсон.	
11	Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах	-	Хуулийн төсөл /тоо/	3	I	IV	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж сайд, яамны удирдлагад танилцуулж, холбогдох ТББ, мэргэжлийн холбоод, Олон улсын байгууллагаар хэлэлцүүлж, Засгийн газрын гишүүдээс санал авахад бэлэн болгов. Түүнчлэн хуулийн төслийг дагалдуулан 20 дагалдах хуулийн төсөл, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээг боловсруулахад хамтран ажиллав. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуульд заасан бүрдүүлбэрийг ханганд Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 01/1454 дугаар албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлэв. УИХ-д өргөн мэдүүлэхтэй холбоотой хуулийн төслийн дэлгэрэнүй танилцуулгыг хуулийн төслийн бүлэг тус бүрээр багцлан тайлбар, танилцуулгыг ажлын хэсэгт боловсруулж өгсөн. Монгол Улсын Их Хурлаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай</p>	100%

хууль”-г 2001 онд баталж, 2011 онд шинэчлэн найруулсан.

Тус яамнаас “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-г хууль эрх зүйн болон практик хэрэгцээ шаардлагын улмаас шинэчлэн найруулахаар төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Тус ажлын хэсэг хэд хэдэн удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллага, оролцогч талуудаас санал, дүгнэлт авч нэгтгэн боловсруулж ХЭДТХ-ийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-нд батлуулсан. Энэ хүрээнд УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэл ханганд ажиллаж байна.

“Гэр булийн хөгжлийг дэмжих тухай хууль” анхдагч хуулийн төслийг шинэчлэн найруулахаар төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Тус ажлын хэсэг хэд хэдэн удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллага, оролцогч талуудаас санал, дүгнэлт авч нэгтгэн боловсруулж хуулийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-нд батлуулсан. Хуулийн төслийг боловсруулахдаа холбоотой Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үр нөлөөний судалгаа, тандан судалгаа, зардлын тооцоог боловсруулахад хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэл ханганд ажиллаж байна.

12	Ядуурлыг бууруулахад салбар дундын уялдаа, оролцоог тодорхойлох, Монгол Улсад ядуурлыг бууруулах стратегийн төсөл боловсруулах	60,000 ам.доллар	Стратегийн төсөл /тоо/	0	II	III	АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2” төслийн худалдан авах ажлын төлөвлөгөөнд тусгасан “Ядуурлыг бууруулах үндэсний стратеги боловсруулах зөвлөх байгууллагыг сонгон шалгаруулах” үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна. Холбогдох хууль журмын дагуу үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж ажилласан. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл - 2” төслийн хугацаа 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болж байгаатай холбогдуулан Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот албан бичгээр 2025 онд санхүүжилт хийх боломжгүй хойшлуулах ажлын жагсаалт ирүүлсэн. Тус яамны удирдлагуудын чиглэл болгосны дагуу төслийн дуусгавар болох хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг эрэмбэлэн үзэж, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02/1333 тоот албан бичгээр уг зөвлөх үйлчилгээг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн.	75%
13	Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, үндэсний хэмжээнд	30,000 ам.доллар	Зөвлөмж /тоо/	0	II	III	АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2” төслийн худалдан авах	75%

	нутагшуулах чиглэлээр зөвлөмж боловсруулах					ажлын төлөвлөгөөнд тусгасан “Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, үндэсний хэмжээнд нутагшуулах чиглэлээр зөвлөмж боловсруулах” зөвлөх байгууллагыг сонгон шалгаруулах” үнэлгээний хороог ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/28 тоот тушаалаар байгуулан ажилласан. Үнэлгээний хорооны гишүүд холбогдох хууль журмын дагуу үнэлгээний хорооны 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хурлыг зохион байгуулж “Impact Research Center NGO” байгууллагыг шалгарулсан. Шалгарсан байгууллагатай гэрээний хэлэлцээ хийх уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 1-ний өдөр зохион байгуулж ажилласан. Сангийн яамнаас 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот албан бичгээр дээрх зөвлөх үйлчилгээг 2025 онд санхүүжилт хийх боломжгүй тул талаар мэдэгдлийг ирүүлсэн. Иймд тус яам болон Монголын улаан загалмай нийгэмлэгийн зөвлөх байгууллага хамтран “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-ийг нутагшуулах зөвлөмжийг дараах байдлаар боловсруулж ажилласан. Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа 2025 оны 08 дугаар сарын 30-аар дуусгавар болж, хөтөлбөрийн үр дүн, холбогдох бичиг баримтыг хүлээлцэх, цаашдын тогтвортой байдлыг хангах
--	--	--	--	--	--	--

							арга хэмжээг ажлын хэсгийн хурал уулзaltaар хэлэлцүүлж ажилласан. Мөн түүнчлэн хөтөлбөрийн чанар, үр дүнг сайжруулах зорилгоор хийгдсэн дотоод уулзалт, сургалт, өдөрлөг арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:	
							<ul style="list-style-type: none"> <li>❖ Хөтөлбөрийн шилжилтийн төлөвлөгөө ГБХНХЯ –ны Төрийн нарийн бичгийн бичгийн даргаар 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр батлуулав.</li> <li>❖ Хөтөлбөрийн шилжилтийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх ажлын хэсгийн уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 18-28-ны өдрийн хооронд зохион байгуулагдав.</li> <li>❖ Өрхийн бие даасан тогтвортой хөгжлийг дэмжих зөвлөмжийг боловсруулан хөтөлбөрийн өрхүүдэд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр танилцуулав.</li> </ul> <p>Хөтөлбөрийг хүлээнцэх шилжилтийн сургалт, хэлэлцүүлгийг нэгдсэн байдлаар 2025 оны 05 дугаар 08-ны өдөр зохион байгуулагдав.</p>	
14	Бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих урт хугацааны хөтөлбөрийг аймаг, дүүрэгт туршилтаар хэрэгжүүлж, төсөлд хамрагдсан өрхийн амьжиргааг дээшлүүлэх	258.0 сая төгрөг	Амьжиргаа дээшилсэн өрхийн хувь	71	I	II	Монгол Улсын урт хугацааны бодлогын барим бичгийг хэрэгжүүлэх, халамжаас-хөдөлмөрт чиглүүлэх зорилтын хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр олон улсад амжилттай хэрэгжиж байгаа Нийгмийн халамж шаардлагатай өрхийн гишүүдийг чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсад туршигдаж, үр дүнд хурсэн “Төгсөлтийн аргачлал”	100%

туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн 1259 өрхийг хамруулан хэрэгжүүлэх 2022 оноос хэрэгжүүлж байна.

"Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-т хамрагдаж байгаа 1259 өрхийг улирал бүр үндсэн 10 шалгуур үзүүлэлтээр өрх тус бүрээр үнэлж байна. 2025 оны 01 дүгээр улирлын үнэлгээгээр нийт өрхийн амьжиргааны түвшин, хөрөнгө ашиглалтын ахиц 84.5 хувьтай байгаа нь нийгмийн халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын зорилтын бодит үр дүн болж байна. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх хүрээнд Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-т хамрагдсан өрхүүдээ цаашид орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, бие даан амьдрах чадавхыг нь сайжруулах, мөн эдгээр өрхийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулахад нь төрийн болон төрийн бус байгууллагатай холбон зуучлах ажлыг сайжруулах зорилгоор Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төвтэй 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр "Хамтран ажиллах" САНАМЖ бичгийг байгуулж ажиллалаа.

"Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-ийг Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй

дүүрэгт туршилтаар хэрэгжүүлж байгаа бөгөөд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, хөтөлбөрийн тогтвортой үр дүнг хадгалах, хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийг цаашид бойжуулж ажиллаад анхаарах мөн дүүргийн түвшинд тулгамдаж буй асуудлын талаар санал, солилцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох чиглэлийг өгч ажиллаа.

Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-т хамрагдаж байгаа өрхийн хөрөнгө ашиглалтын ахицын үнэлгээг хийж байгаа боловч эцсийн үнэлгээ хараахан гараагүй болно.

Олон улсын гэр бүлийн өдрийг тохилдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын "Ажилтай өрх- аз жарталтай гэр бүл" нээлттэй өдөрлөг арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 03/2878 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвшөөлийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан.

Энэ хүрээнд төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн бараа бүтээгдэхүүнийг дэмжих, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласан.

15	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 81, "Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 129 дүгээр конвенцод Монгол Улс нэгдэн орох бэлтгэл ажлыг хангах	Үйл ажиллагааны зардлаар	Конвенцид нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл /тоо/	0	III	IV	ОУХБ-ын "Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 1947 оны 81 дүгээр конвенц, "Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын тухай" 1969 оны 129 дүгээр конвенцод нэгдэн орох хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу хийж байна. Хугацаа болоогүй.	XБ
16	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартад улсын үзлэг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Үзлэгт хамрагдах стандартын хувь	2018 оны улсын үзлэг	I	II	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудад улсын үзлэг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг болон удирдамжийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/22 дүгээр тушаалаар баталж, улсын үзлэгийг зохион байгуулан ажилласан. Стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн 156 стандартыг улсын үзлэгт хамруулсан. Стандартын улсын үзлэгийн дүнгээр нийт 156 стандартын 47 нь буюу 30.1 хувийг нийтэд нь дахин хянах, 57 нь буюу 36.5 хувийг хүчингүй болгох, 46 нь буюу 29.5 хувийг хэвээр мөрдөх, 6 нь буюу 3.8 хувийг холбогдох заалтыг хянах, 22 нь буюу 14.1 хувийг техникийн зохицуулалт болгох нь зүйтэй гэж дүгнэсэн. Энэ ажлын үр дүнд үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шинэчлэлийн 2025-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг	100%

							боловсруулан 2025 оны А/97 дугаар тушаалаар батлуулсан. Дээрх улсын үзлэгийн тайланг Стандарт, хэмжил зүйн газарт 2025 оны 03/989 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
17	Асбесттэй харьцах аюулгүй ажлын техникийн зохицуулалтын төслийг боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл /тоо/	0	III	IV	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/118 дугаар тушаалаар “Асбесттэй харьцах аюулгүй ажлын техникийн зохицуулалт”, “Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хугацаа болоогүй	XБ
18	Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтын төслийг боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл /тоо/	0	III	IV	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/118 дугаар тушаалаар “Асбесттэй харьцах аюулгүй ажлын техникийн зохицуулалт”, “Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хугацаа болоогүй	XБ
19	YAMAT-08-д ангилагдсан ажил мэргэжлээс сонгон ажил мэргэжлийн профайл боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	Боловсруулсан ажил мэргэжлийн профайл /тоо/	0	I	II	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон холбогдох мэргэжлийн холбоод, салбарын мэргэжилтнүүдтэй ажил мэргэжлийн профайл боловсруулахад хамтран ажиллалаа. Үүний үр дүнд ГБХНХ-ын сайдын 2025 оны А/79 дугаар тушаалаар 93 ажил мэргэжлийн профайл батлагдсан. Тушаалаар 13 ажил мэргэжил шинээр нэмж, 69 ажил мэргэжлийн нэршилд	100%

							өөрчлөлт оруулж, 24 ажил мэргэжлийг хүчингүй болгосон.	
20	Бүтээмжийн үндэсний мастер төлөвлөгөөний төслийг боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл /too/	0	I	IV	<p>Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн холбоотой хамтран үндэсний бүтээмжийн үзэл баримтлалыг тодорхойлж, үндэсний хэмжээнд бүтээмжийн хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилго бүхий БҮТЭЭМЖИЙН ХУВЬСАЛ чуулганыг зохион байгуулсан.</p> <p>Монгол Улсын хөдөлмөрийн дундаж бүтээмж дэлхийн дунджаас 3.6 дахин, БНСУ-аас 5.4 дахин бага байна. Манай Улсад уул уурхай, мэдээлэл технологийн салбар хамгийн их бүтээмжтэй, цалин өндөр байна.</p> <p>Иймээс аж ахуйн нэгж байгууллага, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, улсын хэмжээнд хөдөлмөр, технологи, менежментийн үр ашигт байдалд сууринсан бүтээмжийг тогтвортой өсгөх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, нөөцийг оновчтой хуваарилах, ашиглалтыг хангах, Олон улсын шинэлэг, үр дүнтэй, оновчтой хэрэгжиж байгаа туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, арга зүйг тодорхойлох зорилгоор “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө” боловсруулахаар ажиллаж байна.</p> <p>Энэ хүрээнд Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн төв ТББ-ын төлөөлөл, Үндэсний статистикийн хороо, XHXSUCI, MMCG ХХК-ийн судалгааны багийн төлөөлөл болон яамны холбогдох газар,</p>	75%

							хэлтсийн мэргэжилтнүүдийг оролцуулан 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр танхим болон цахим уулзалтыг тус тус зохион байгуулж, санал солилцлоо. Мөн бүх яамдын төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, оролцогч талуудаас гаргасан санал дүгнэлт, зөвлөмжид үндэслэн Бүтээмжийн үндэсний мастер төлөвлөгөөний төслийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулахаар бэлтгэл ханганд ажиллаж байна.	
21	Цагаан сар, Үндэсний баяр наадмын өдрүүдтэй холбоотой хууль тогтоомжид өөрчлөлт оруулахтай холбоотой Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл боловсруулах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Тэмдэглэл төсөл	0	I	IV	Монгол үндэстний уламжлалт баяр Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1 тасарч, шинийн 2, 3-ны өдөр Бямба, Ням гарарт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарарт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийхтэй холбоотой ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүллээ.	100%
22	Ажлын өдөр/ ажлын цагийг багасгахтай холбоотой судалгаа хийх	-	Судалгааны төсөл	0			Нийтээр амрах баярын өдрийн зохицуулалт, Жаргалтай өвөл зэрэг ажлын өдөр/ ажлын цагтай холбоотой	100%

							судалгаа хийж, мэдээлэл бэлтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 1 дүгээр сард хүргүүллээ. Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 29-ны хуралдаанд танилцууллаа.	
23	"Эхийн алдар" одонгоор шагнах журмын төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах, хууль тогтоомжийн шинэчлэлийн санал, хувилбар боловсруулах	-	Хууль тогтоомжийн төсөл /тоо/	0	I	-	ЕТГ-аас байгуулсан "Эхийн алдар" одонгоор шагнах журам боловсруулах ажлын хэсэгт ТНБД Л.Мөнхзүүл ажилласан. ТНБД-аас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу одонтой эхчүүдийн талаарх мэдээлэл болон Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бэлтгэж өгөв. Мөн Эхийн алдар одонгоор шагнах журмын төсөлтэй танилцан санал болон холбогдох төсвийн тооцооллыг боловсруулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар зарлигаар "Эхийн алдар" одонгоор шагнах журам батлагдсан.	100%
24	"Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан"-ы хүрээнд "Ажиллах хүчний бүтээмж, нийгмийн хамгаалал"-ын салбар хуралдааныг бус бүрд зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Зохион байгуулсан салбар хуралдаан /тоо/	7	I	II	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл, мөн 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл, Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтооолоор Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан, бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулахаар шийдвэрлэсэн.	100%

Дээрх тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтыг хangan ажиллах чиг үүрэг бүхий ГБХНХС-ын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг ажиллаж байна.

Тус ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Хангайн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан Архангай аймагт зохион байгууллаа. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" албан даалгаврын 4.2.1-д заасны дагуу тус салбаргаас бүсчилсэн хөглийн бодлоготой уялдуулан, бүс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх төслийн саналыг гарган хүргүүлсэн. Мөн Хангайн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлт, бизнес аж ахуй эрхлэлтийг дэмжих, гарааны болон бичил, жижиг бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн орчныг сайжруулах, хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс,

хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран зорилтот бүлгийн иргэний үүсгэн байгуулсан болон Хангайн бүсийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Хөгжлийн гүүр” туршилтын төслийг танилцуулсан болно. Тус хуралдааны хүрээнд Засгийн газрын 181, 182 дугаар тогтоол гарсан.

2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ТНБД-ын А/130 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Хойд бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт ажиллалаа. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар ГБХНХ-ын сайд Хойд бүсийн хөгжил-2040 салбар хуралдаанд панелистаар оролцож Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний талаар хэлэлцсэн. Тус хуралдаантай холбогдуулан Засгийн газрын 2025 оны 20 дугаар хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 204, 209 дүгээр тогтоол гарсан.

2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн ТНБД-ын А/147 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Говийн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дорноговь аймагт ажиллалаа.

Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар ГБХНХ-ын сайд, ажлын

							хэсгийн бүрэлдэхүүн Говийн бүсийн хөгжил-2040 салбар хуралдаанд оролцсон. Тус хуралдаанаар Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, Засгийн газрын 2025 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 235 дугаар тогтоол гарсан. Төвийн болон бусад бусуудэд зохион байгуулагдах Засгийн газрын өргөтгөсөн хуралдаан цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон болно.	
<b>ЗОРИЛТ 2. САЛБАРЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
25	НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөлийн эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 69 дүгээр чуулганд оролцож, бэлтгэл ажлыг хангах	Үйл ажиллагааны зардал	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	I		2025 оны 03 дугаар сарын 09-21-ний өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн эмэгтэйчүүдийн аж байдлын 69 дүгээр чуулганд Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзулаар ахлуулсан төлөөлөгч нар Ерөнхий хэлэлцүүлэгт Монгол Улсын сүүлийн 30 жилд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхийг хангах чиглэлээр манай улсын олсон амжилт, үр дүнгээс танилцуулсан. Чуулганы үеэр Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзүл Монгол, Аргентин, Турк, Шинэ Зеланд, Европын Холбооны төлөөлөгчийн газраас хамтран зохион байгуулсан “Бээжин+30: Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг устгах хариуцлагыг дээшлүүлэх асуудал” сэдэвт арга хэмжээнд уг хэлэхийн зэрэгцээ мэн асуудлаар ИБУИНХУ,	100%

								Канад, Колумб, Мексик, Францын өндөр түвшний төлөөлөгчидтэй ажил хэргийн уулзалтад оролцож, манай улсад эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг устгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг танилцуулж, туршлага солилцож ажилласан. ЭБАК-ын 69 дүгээр чуулганаас Дэлхийн эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр бага хурлын 30 жилийн ойд зориулсан Улс төрийн тунхаглал болон ЭБАК-ын дараачийн жилүүдийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай тогтоолыг батлав.	
26	Олон Улсын Хөдөлмөрийн 113 дугаар бага хуралд оролцох, бэлтгэл ажлыг хангах	Үйл ажиллагааны зардал	Бага хурал	1	II	-	Олон улсын хөдөлмөрийн Бага хурлын 113 дугаар чуулган 2025 оны 6 дугаар сарын 2-13-ны өдрүүдэд Швейцарын Холбоон Улсын Женев хотноо зохион байгуулагдлаа. Чуулганд Монгол Улсыг төлөөлж Засгийн газар, ажил олгогч болон ажилтны төлөөлүүд оролцсон. Монгол Улсын төлөөлөгчдийг НҮБ-ын Женев дэх төв болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Гэрэлмаа ахалж оролцсон бөгөөд чуулганы 6 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Монгол Улсад зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хууль, эрх зүйн орчны шинэчлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулж уг хэлэв.	100%	

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 187 гишүүн орны гурван талын 6,000 гаруй төлөөлөгч хуран цугласан ээлжит чуулганаар биологийн аюултай хүчин зүйлээс хамгаалах тухай олон улсын конвенц, зөвлөмж батлах асуудлаарх хоёр дахь хэлэлцүүлэг, платформ эдийн засагт зохистой хөдөлмөрийг хангах талаар олон улсын конвенц боловсруулах асуудлаарх эхний хэлэлцүүлэг, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулж, албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэлэг арга зам, энэ оны 11 дүгээр сард Доха хотноо болох Нийгмийн хөгжлийн асуудлаарх дэлхийн хоёрдугаар чуулга уулзалтад ОУХБ-аас дэвшүүлэх гурван талт санал, зөвлөмж, Далайн хөдөлмөрийн тухай конвенцын Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, ОУХБ-ын суурь конвенциудын хэрэгжилт зэрэг болон холбогдох бусад асуудлыг хэлэлцэв. Түүнчлэн чуулганаар ОУХБ-ын 2026-2027 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн төслийг хэлэлцэн батлав. Төлөөлөгчдийн ахлагч Д.Гэрэлмаа Монгол Улсын Засгийн газраас Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-тай хамтран хөдөлмөр эрхлэлтийн хууль, эрх зүйн орчны цогц үнэлгээ хийж, хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжоо шинэчлэх, албадан хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгахад анхаарч ажиллаж байгаагийн зэрэгцээ байгаль орчны тогтвортой байдал,

								зохистой хөдөлмөр эрхлэлтийг хослуулах замаар ногоон эдийн засагт шилжих шилжилтийг дэмжиж, сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийж, ногоон ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж байгааг таницуулав. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар 2025 онд нийгмийн хамгааллын хүртээмжийг сайжруулах, тэтгэмж олгох ажлыг цахимжуулах, тэтгэврийн тогтолцоог шинэчилж, нийгмийн даатгалын тогтолцоог илүү хүртээмжтэй, шуурхай болгох шинэчлэлийн алхмуудыг авч хэрэгжүүлж байгааг мэдээлэв. Нийгмийн гурван талт яриа хэлэлцээ нь Монгол Улсын хөдөлмөрийн бодлогын тулгын чулуу болохыг Байнгын төлөөлөг онцолж, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо нь хөдөлмөрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, зохистой хөдөлмөрийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийн шинэ тутам асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэсээр байгааг тэмдэглэлээ.	
27	Монгол Улс, гадаад улс хоорондын гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулах	Үйл ажиллагааны зардал	Боловсруулсан баримт бичгийн тоо	1	I	IV	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Австри Улсын Европ, олон улсын харилцааны яамны Ерөнхий нарийн бичгийн дарга Николаус Маршик нар 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс	100%	

							хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурсан. -Монгол Оросын Засгийн газар хоорондын 1981 онд байгуулагдсан "Нийгмийн хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг шинэчлэхээр 2018 оноос 2 талын шинжээчдүн ажлын хэсэг ажиллаж, нийт 4 удаагийн хэлэлцээ хийсэн. -Монгол Улс, Австрали Улсын Засгийн газар хоорондын "Нийгмийн хамгааллын хэлэлцээр"-ийн 2 удаагийн хэлэлцээг цахим хэлбэрээр хийсэн. Энэ оны II хагаст Австрали Улсын Засгийн газрын төлөөлөгчид Монгол Улсад биечлэн ирж, хэлэлцээг ургэлжлүүлэн хийнэ.	
28	Олон улсын байгууллага, донор байгууллагуудтай салбарын бодлогын хүрээнд хамтран ажиллах	Үйл ажиллагааны зардал	Хэрэгжүүлсэний төсөл хөтөлбөрийн тоо	0	I	IV	Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусlamжийн санхүүжилтээр 2.6 жилийн хугацаанд хэрэгжүүлэх "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих /ҮЕР/ төсөл" 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр нээлтээ хийж, албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Уг төсөл нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх, ажлын байрны менежментийг сайжруулах арга хэрэгслийг түгээн дэлгэрүүлэх зорилготой. Азийн хөгжлийн банктай хамтран "Дасан зохицох, тэсвэртэй нийгмийн хамгааллын төсөл"-ийг хэрэгжүүлэх зорилгоор энэ оны 1 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд болон 5 дугаар сарын 5-9-ний өдрүүдэд хамтарсан баг	100%

							ажилласан болно. Хамтарсан багийн ажлын хүрээнд уг төслийн зорилго, цар хүрээ, зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн болон хэрэгжүүлэх цаг хугацаа зэргийг тохирсон 2 удаагийн санамж бичиг /aide memoire/ байгуулсан.	
--	--	--	--	--	--	--	--	--

Төлөвлөгөөг үнэлсэн:

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

(албан тушаал)

Тэмдэг

— Төсвийн шууд захирагч

/Л.МӨНХЗУЛ/

(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

Нэгжийн дарга  
(гарын үсэг)

/Д.РЕНЧИНДОРЖ/

(огноо)

Тайлagnасан:

НЭГДСЭН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

Нэгжийн дарга

/Б.АЛИМАА/

(гарын үсэг)

(огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
8 дугаар хавсралт

**НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА Б.АЛИМААГИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Нэгжийн нэр: Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	93,6	65.52

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1. Цалин, хүний хүний нөөц, нийгэм, эдийн засгийн олон улсын арга хэмжээнд хамрагдах туршлага судлах	100	15
2.	Арга хэмжээ 2. Хүний нөөц, чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдах	100	15
<b>Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо</b>			<b>15</b>

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	15

8.	Мэргэжлийн ур чадвар 2.	15
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	15
	<b>Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо</b>	<b>15</b>

#### 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо <b>65.52</b>
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )	15 хүртэлх оноо <b>15</b>
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )	15 хүртэлх оноо <b>15</b>
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	..... оноо
	<b>Нийт оноо =</b> ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	<b>95.52</b>

Үнэлгээ өгсөн:

Төрийн нарийн бичгийн дарга

(албан тушаал)



Төсвийн шууд захирагч

/ Л.Мөнхзул /

(албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:

Нэгдсэн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга

(албан тушаал)

Нэгжийн дарга:

.....

/ Б.Алимаа/

(гарын үсэг)

(албан хаагчийн нэр)

..... (огноо)